



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/54

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 тоот тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газар (РД:9033556)-т төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд (төмс, хүнсний ногоо тариалах) зориулалтаар 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт Үйзэн мандал хоршооны өвс, тэжээлийн агуулахын урд талд 2 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

